



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 4/354

Ховд

Г Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8/04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын аймгийн төсвийн эрх захирагч нарын 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн Мал эмнэлгийн үйлчилгээний 8.1 дэх заалтын Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 10.7 сая, 8.2 дахь заалтын лабораторийн шинжилгээний 4.3 сая, 8.3 дахь заалтын вакцинжуулалтын мониторинг үнэлгээ хийх 4.5 сая төгрөг, 3 дугаар хавсралтын орон нутгийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 5.1 дэх заалтын Малын эрүүл мэнд дэд хөтөлбөрийн 30.0 сая төгрөгийг тус тус зарцуулах эрхийг Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтыг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын эрүүл мэнд аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, хэрэгжүүлсэн ажлын үр дүнг 10 дугаар сарын 20-ны дотор тайлагнахыг Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгө оруулалтын зарцуулалт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 01775
Zax A/354 Ch